



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/267

Чингис хот

Аймгийн хэмжээнд коронавируст халдвар
(Covid-19)-ын эсрэг вакцинжуулалтын зардал болон
халдваргүйтгэлийн нөөцийг бүрдүүлэхэд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.12, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.4, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Онцгой комиссын 2021 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 17 дугаар хуралдааны шийдвэрийн дагуу коронавируст халдварын эсрэг вакцинжуулалтын зардал болон халдваргүйтгэлийн нөөцийг бүрдүүлэхэд шаардлагатай хөрөнгийг Зооноз өвчин судлалын төвд олгосугай.

2. Дээрх зардалд шаардлагатай 29.505.000 (хорин есөн сая таван зуун таван мянган) төгрөгийг Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.

3. Хөрөнгө зарцуулах тооцоог хавсралтаар баталсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

06 Аймгийн Засаг даргын 2021 оны
 дугаар сарын 03 өдрийн А/267
 дугаар захирамжийн хавсралт

	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Шаардлагатай хамгаалах хэрэгсэл	
			Тоо хэмжээ	Мөнгөн дүн
2	Аюулгүйн хайрцаг	ширхэг	30	126000
3	1 удаа өмсгөл	ширхэг	500	7500000
13	Нэг удаагийн малгай	ширхэг	500	90000
18	Түрийтэй углааш	ширхэг	500	1250000
	үзлэгийн бээлий	Хос	10000	7000000
27	Хогны уут	ширхэг	19	114000
			11,549	16,080,000

Д/Д	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Вакцинд шаардлагатай		
			Үнэ	Тоо хэмжээ	Нийт үнэ
1	Нэг удаагийн малгай	ширхэг	250	4000	1000000
2	үзлэгийн бээлий	Хос	700	15000	10500000
3	Аюулгүйн хайрцаг	ширхэг	5200	200	1040000
4	Бинт	ширхэг	2000	150	300000
5	Цаасан наалт	ширхэг	1500	140	210000
6	Цэнхэр спирт	ширхэг	7500	50	375000
	дүн		17,150	19,540	13,425,000